



ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Эрчим хүчний хэмнэлтийн газрын дарга
Ц.АТАРЖАРГАЛ*

УЛААНБААТАР
2021 он

Агуулга:

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр танилцуулга

Ач холбогдол, үр нөлөө

ЭХХҮХ-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Хэрэгжүүлэх арга зам, хамтын ажиллагаа



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 9 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 274

Улаанбаатар
хот

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 5.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2017 онд багтаан баталж, хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллахыг Эрчим хүчний сайдын үүрэг гүйцэтгэгч П.Ганхүүд даалгасугай.

3. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвийн төсөлд тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайдын үүрэг гүйцэтгэгч П.Ганхүү, Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Чойжилсүрэн болон Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган хэрэгжилтэд нь хяналт тавьж, явцыг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт тайлагнаж байхыг Эрчим хүчний сайдын үүрэг гүйцэтгэгч П.Ганхүү, Эрчим хүчний зохицуулах хороо (А.Тлейхан)-нд үүрэг болгосугай.

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр /2018-2022он/



Ерөнхий
Зорилго

18 зорилт

53 үйл
ажиллагаа

30 шалгуур,
үр дүн



ЗОРИЛГО: Эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган **уялдуулах**, инновацид суурилсан эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт техник, технологи **нэвтрүүлэх**, **хэрэглэх** замаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, **уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад** энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.



4.1

“Эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.1.1

Эрчим хүч хэмнэлтийн хууль тогтоомж болон түүнийг дагаж гарсан зохицуулалтын баримт бичгийг бусад хууль тогтоомжтой уялдуулах, холбогдох стандарт, норм, нормативыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

4.1.2


Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журмыг баталж мөрдүүлэх;

4.1.3

Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох журмыг баталж мөрдүүлэх;

4.1.4

Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага, мэргэжлийн үйлчилгээ, үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх, сайжруулах.



4.2

“Эрчим хүч хэмнэх үйл ажиллагааны уялдаа холбоог хангасан үр ашигтай хэрэглээг дэмжсэн удирдлага, мэдээллийн системийг хөгжүүлж хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг



4.2.1

Эрчим хүч хэмнэлтийг бий болгох, дэмжих чиглэлээр ажиллаж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын мэдээллийн санг бий болгох, үйл ажиллагааг уялдуулах, тасралтгүй, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, сурталчлах;

4.2.2

Эрчим хүч хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаар хэрэглэгчдэд зориулсан үндэсний мэдээллийн цахим системийг бий болгож хэрэглээнд нэвтрүүлэх, үйл ажиллагааг нь өргөжүүлэх.



4.3

”Эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.3.1

Эрчим хүч хэмнэлтийн талаарх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургагч багш нарыг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах;

4.3.2


Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежерийг бэлтгэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

4.3.3

Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтын байгууллагыг хөгжүүлж, үйл ажиллагааг нь дэмжих;

4.3.4

Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламжийн зураг төсөл хийх, барьж байгуулах, үйлдвэрлэл үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр холбогдох инженер, техникийн ажилтныг чадавхжуулах.



4.4

”Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн дагуу үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэх замаар хэмнэлтийг бий болгох” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.4.1

Эрчим хүчний хэмнэлттэй технологи, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ нэвтрүүлэх, нутагшуулахад төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах, гааль, татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх;

4.4.2

Эрчим хүч хэмнэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зохицуулалтыг бий болгож, байгаль хамгаалахад чиглэсэн олон улсын байгууллагаас хөрөнгө оруулалт хийх боломжийг судалж, хэрэгжүүлэх.



4.5


”Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг сайжруулах замаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.5.1 Монгол Улсын эрчим хүчний балансыг тооцох үндэсний аргачлалыг баталж нэвтрүүлэх;

4.5.2 Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээнээс ялгарч байгаа хүлэмжийн хийг тооцох үндэсний онцлогт тохирсон аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, үндэсний хэмжээний хүлэмжийн хийн тооллогын системийг бэхжүүлэх;

4.5.3 Эрчим хүч хэмнэлтийн үр дүнгээс бий болж байгаа хүлэмжийн хийн бууралтыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах үндэсний системийг бүрдүүлж, нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх.



4.6

”Эрчим хүч хэмнэлт, үр ашигтай хэрэглээний талаарх хичээлийг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт тусгах, олон нийтэд чиглэсэн мэдлэг, мэдээллийг түгээх замаар эрчим хүчний зохистой хэрэглээг бий болгож төлөвшүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.6.1

Эрчим хүч хэмнэлтийн үр ашиг, ач холбогдлын талаарх мэдлэгийг иргэд олон нийтэд сурталчлах, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх, эрчим хүчийг хэмнэх үндэсний өдөртэй болох;

4.6.2

Эрчим хүч хэмнэлт, зохистой хэрэглээний чиглэлээр хичээлийг ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах арга хэмжээ авах;

4.6.3

Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, тоног төхөөрөмж, технологийн үзэсгэлэнгийн төв байгуулж, хэрэглэгчдийг мэдээллээр тасралтгүй хангах нөхцөлийг бүрдүүлэх.



4.7

“Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд эрчим хүчний хэмнэлттэй технологийг үе шаттайгаар нэвтрүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.7.1

Гудамж, зам, талбай, нийтийн эзэмшлийн газарт ашиглаж байгаа гэрэлтүүлгийг үе шаттайгаар эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэгт шилжүүлэх;

4.7.2

Шинээр барьж байгуулахаар төлөвлөж байгаа гудамж, зам, талбайн гэрэлтүүлэг эрчим хүчний хэмнэлттэй байх шаардлагыг тавьж хэрэгжүүлэх;

4.7.3

Технологийн онцлогт хамааралгүй бүх төрлийн улайсах чийдэнгийн хэрэглээг багасгах.

22,750 төг/жил

175 кВт.ц



60 Вт

Чийдэнг өдөрт 8 цаг асаана.

*Жилд асаах цаг $8 * 365 = 2,920$ цаг*

Цахилгааны дундаж тариф: 130 төг/кВт.ц

3,380 төг/жил

26 кВт.ц



9 Вт

1,950 төг/жил

15 кВт.ц



5 Вт

4.8

“Төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, бусад төсөвт байгууллагын эрчим хүчний хэрэглээг бууруулах, хэмнэлт гаргах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.8.1

Эрчим хүч хэмнэлтээс бий болсон жилийн урсгал зардлын хэмнэлтийг эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үйл ажиллагаанд зарцуулах тогтолцоог бүрдүүлэх;

4.8.2

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах бүтээгдэхүүн, бараа, ажил, үйлчилгээ, тоног төхөөрөмжид эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын хугацааны зардал бага байх



Нийтлэг барилгаас 1,9 дахин их
Нормын дагуу 6,2 дахин их

4.9

”Аймаг, нийслэл, сум, дүүрэгт баримтлах эрчим хүч хэмнэлтийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:




4.9.1

Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн онцлогт тохирсон эрчим хүч хэмнэлтийн талаарх бодлогыг тодорхойлж аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган


4.9.2

Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тодорхой хувийг эрчим хүчний хэмнэлтийг дэмжсэн арга хэмжээнд зарцуулах.



4.10

”Эрчим хүчний үйлдвэрлэлийн дотоод хэрэгцээнд зарцуулах эрчим хүч, түлшний хувийн зарцуулалтыг бууруулах” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.10.1

Дулааны цахилгаан станцын технологийн шат дамжлага, тоног төхөөрөмжийн горимын ашиглалтын түвшинг тогтоож, удирдлага, хяналтыг тоон системд үе шаттайгаар шилжүүлэх, үр ашгийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;


4.10.2

Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн түлшний хувийн зарцуулалтыг бодитоор тооцож бууруулах;

4.10.3 Дулааны цахилгаан станцын уур, усны алдагдлыг бууруулах арга хэмжээ авах.



ДХЦЭХ %



4.11

“Эрчим хүч дамжуулах, түгээх үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлж, цахилгаан болон дулаан түгээлтийн алдагдлыг бууруулах” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:




4.11.1 Эрчим хүч дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны удирдлага, хяналт, мэдээллийн системийг тоон системд үе шаттай шилжүүлж, горим зохицуулалтын үр ашигтай тогтолцоог

4.11.2 Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх;

4.11.3 Нэгдсэн сүлжээний цахилгаан эрчим хүчний болон төвлөрсөн дулаан хангамжийн төлөвлөлт, горим, диспетчерийн нэгдсэн зохицуулалтын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх.



дам, түгээлтийн алдагдал ТБНС %



4.12

"Эрчим хүчний хэрэглэгч талын менежментийг хөгжүүлэх" зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.12.1

Эрчим хүчний нэгдсэн сүлжээний цахилгаан ачааллын хэлбэлзлийг тохируулах техник, эдийн засаг, зохион байгуулалтын арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;

4.12.2

Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс үйлдвэрлэсэн цахилгааныг түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хэрэгжүүлэх;

4.12.3

Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон орон сууцны барилгын халаалтын системд дулааны тохируулга хийх, хэрэглэгчдийг бүрэн тоолууртай болгох арга хэмжээ авах;

4.12.4

Хэрэглэгчид хүргэх эрчим хүчний чанарыг сайжруулах.



4.13

“Эрчим хүчний хэмнэлтийг тарифын бодлогоор дэмжих” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.13.1 Дулааны эрчим хүчний бодит өртгийг тодорхойлж, тарифын шинэтгэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

4.13.2 Дулааны эрчим хүчний хэрэглээг барилга байгууламж, орон сууцны эзлэхүүн, талбайгаар, албан байгууллага, айл өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг задгайгаар болон хүний тоогоор тооцож байгаа одоогийн тогтолцоог тоолууржуулах замаар бүрэн халах;

4.13.3 Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, бодит хэмнэлт гаргасан тохиолдолд урамшуулах тогтолцоог бий болгох;

4.13.4 Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх тарифын бодлогыг хэрэгжүүлэх.



4.14

“Барилга байгууламжийн эрчим хүчний хэрэглээний түвшинг тодорхойлж, гэрчилгээ олгох” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.14.1 Барилга байгууламжийн эрчим хүчний хэрэглээний түвшинг тодорхойлох аргачлал боловсруулах;

4.14.2 Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгад (пассив барилга) тавигдах үндэсний шаардлагыг тодорхойлж сурталчлах;

4.14.3 Эрчим хүчний аудитыг барилгын салбарт үе шаттайгаар хийж эрчим хүчний хэрэглээний түвшинг тодорхойлж, гэрчилгээ, шошго олгох ажлыг зохион байгуулах;

4.14.4 Барилгын материал, бүтээгдэхүүний гарал үүслийн тодорхойлолт, лабораторийн дүгнэлтийг үндэслэн шошгожуулах ажлыг хэрэгжүүлэх;

4.14.5 Орон сууцны барилгын дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг дэмжих санхүүгийн хөшүүрэг, ногоон моргейжийн хөтөлбөр бий болгох.



4.15

“Барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, хэрэгжилтийг хангуулж, гүйцэтгэлд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.15.1 Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг эрчим хүчний хэмнэлттэй болгох чиглэлээр боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэх;

4.15.2 Эрчим хүч хэмнэлт, үр ашгийг тодорхойлсон тооцоолол, үзүүлэлт, дүгнэлтийг барилга байгууламж барих явцад тавих хяналт, ашиглалтад хүлээн авах үе шатанд бүрдүүлэх бичиг баримт, материалын бүрдэлд оруулах арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангах;

4.15.3 Нэн тэргүүнд дулаалах шаардлагатай барилгыг тодорхойлж, дулааны алдагдлыг 20 хувиар бууруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.



4.16

“Аж үйлдвэрийн салбар дахь нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээнд зарцуулах эрчим хүчний зарцуулалтын нормыг тодорхойлж, эрчим хүчний зарцуулалтыг үе шаттайгаар бууруулах” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.16.1

Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээнд зарцуулах эрчим хүчний зарцуулалтад судалгаа хийж тодорхойлох, нормчлох ажлыг үе шаттай хэрэгжүүлэх;

4.16.2

Эрчим хүчний хэмнэлттэй, үр ашигтай технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд шаардлагатай зөвлөмж, мэдээллээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг тогтмол хангах.

4.17

“Инновацид суурилсан эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт техник, технологи бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.17.1

Эрчим хүчний хамгийн бага зарцуулалттай тоног төхөөрөмжийг үйлдвэрлэл, үйл ажиллагаанд ашиглах шаардлагыг тодорхойлж нэвтрүүлэх;

4.17.2

Эрчим хүчний удирдлагын тогтолцоо MNS ISO-50001:2014 стандартыг үе шаттайгаар нутагшуулах.


4.18

“Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, эрчим хүчний нөөцийн үр ашигтай тээврийн хэрэгслийн хэрэглээг дэмжсэн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.18.1 Автотээвэрт хийн ба хосолмол түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, түлш бага зарцуулдаг тээврийн хэрэгслийг бодлогоор дэмжих;

4.18.2 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд цахилгаан тээврийн оролцоог нэмэгдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөө багатай түлшээр ажилладаг тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх.



Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

6.1.3.эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд сөрөг нөлөө багатай дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үйл ажиллагаандаа ашиглах боломж бүрдсэн байна.

6.1.2.эрчим хүч хэмнэх талаар хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирсан байна.


6.1.
Хөтөлбөрийг
хэрэгжүүлснээр
дараах үр дүнд
хүрнэ:

6.1.4.эрчим хүчийг үр ашигтай зарцуулахад чиглэсэн нийтийн боловсролыг дэмжсэн арга хэмжээг хэрэгжих, иргэд, олон нийтэд эрчим хүчийг хэмнэх, зохистой хэрэглэх арга барил төлөвшсөн байна.



6.1.1.эрчим хүч хэмнэлтийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин цогц байдлаар бүрдэнэ.

6.1.5.эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээнээс бий болж байгаа байгаль, экологийн бохирдол, хүлэмжийн хийн ялгарал бодитоор буурсан байна.

Эдийн засаг ба Эрчим хүч



Нөлөөлөл ба таамнал





Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох

Хуулийн дагуу Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг тодорхойлж, 2016, 2017, 2018 онуудад ЭХЗХ-ны мэдэгдэл хүргүүлээд байна.



Эрчим хүч хэрэглэгчдийн бүтцээр:



1988 сая кВт.ц=57%

Бодит боломж:

ЭХЗХ, Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагатай эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн чиглэлд хамтран ажиллахаар байгуулсан санамж бичгийн хүрээнд эрчим хүчний аудитын жишиг төслийг 15 байгууллагад 5 сарын хугацаанд хэрэгжүүлсэн.

Төслийн гүйцэтгэгч:

Прайсуотерс Куперс (PwC) - Олон улсад аудитын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компани

№	Үүрэг хүлээсэн хэрэглэгчид	Салбар
1	Багануур ХК	Уул уурхай
2	Налайхын Дулааны Станц ТӨХК	Дулааны эрчим хүч
3	Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК	Дулаан түгээлт
4	Дулааны 3 дугаар Цахилгаан Станц ТӨХК	Эрчим хүч үйдвэрлэл
5	Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК	Эрчим хүч түгээлт
6	Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевиз	Барилга (Телевиз Радио)
7	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль	Барилга (Боловсрол)
8	Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг	Барилга (Эмнэлэг)
9	Ачит Ихт ХХК	Зэсийн үйлдвэр
10	Эрдэнэт Хивс ХХК/Орхон Инженеринг Менежмент ХХК	Хивс/Ноос үйлдвэрлэл
11	Витафит Инвест ХХК	Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
12	Чингис Хаан Зочид Буудал	Барилга (Зочид буудал)
13	Сүү ХК	Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
14	Говь ХК	Ноолууран эдлэлийн үйлдвэрлэл
15	Махимпекс ХК	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Төслийн үр дүн 15 байгууллагын хэмжээнд:

Жилд гаргах хэмнэлт - 259.7 сая кВт.ц цахилгаан эрчим хүч буюу 35.1 тэрбум төгрөг

Хөрөнгө оруулалтын зардлаа нөхөх хугацаа: 3 жил

Нийт буурах CO₂ - 620 гаруй мянган тонн

АРГА ХЭМЖЭЭ #1

Махны зoorны температурыг -8°C стандарт хэмийг барихын тулд температур тохируулагчийг солих

23,285 кВт.цаг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

4.23 сая.төгрөг

Эрчим хүч зардлын хэмнэлт (жил тутамд)

1 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

3 сар

Хоронго оруулалтын зардал нөхөх хугацаа

24.71 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #2

Дулааны болон хэрэгцээний халуун усны шугамын насосд давтамж хувьсгуур суурилуулах

32,040 кВт.цаг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

5.82 сая.төгрөг

Эрчим хүч зардлын хэмнэлт (жил тутамд)

7.83 сая.төгрөг

Шаардагдах хөрөнгө оруулалт

16 сар

Хоронго оруулалтын зардал нөхөх хугацаа

33.99 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #3

Угаалгын өрөөний цахилгаан индүүдлэгийг төхөөрөмжийг халуун усаар халдаг индүүдлэгийн төхөөрөмжөөр солих

-

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

6 сая.төгрөг

Эрчим хүч зардлын хэмнэлт (жил тутамд)

10 сая.төгрөг

Шаардагдах хөрөнгө оруулалт


20 сар

Хөрөнгө оруулалтын зардал нөхөх хугацаа

-

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХЭМНЭЛТИЙН ТӨСӨЛ П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ УЛСЫН III ТӨВ ЭМНЭЛЭГ



Нийт цахилгааны хэрэглээ
(2016) (кВт.цаг): 1,979,130

АРГА ХЭМЖЭЭ #6

Зүрхниймэс заслын өрөөний агаар цэвэршүүлэгчид давтамж хувьсгуур суулган тасалгааны температурыг 21°C-ээс 23°C хэмд барих

12,434 кВт.цаг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

2.26 сая.төгрөг

Эрчим хүч зардлын хэмнэлт (жил тутамд)

5.5 сая.төгрөг

Шаардагдах хөрөнгө оруулалт

29 сар

Хөрөнгө оруулалтын зардал нөхөх хугацаа

13.19 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #4

Эмнэлгийн бүх нэгжийн чийдэнг эрчим хүчний хэмнэлттэй LED чийдэнгээр солих

800,766 кВт.цаг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

145.44 сая.төгрөг

Эрчим хүч зардлын хэмнэлт (жил тутамд)

258 сая.төгрөг

Шаардагдах хөрөнгө оруулалт

21 сар

Хөрөнгө оруулалтын зардал нөхөх хугацаа

84.9 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #5

Цилиндрийн компрессорыг эрчим хүчний үр ашигтай шурган компрессороор солих

7,767 кВт.цаг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

1.41 сая.төгрөг

Эрчим хүч зардлын хэмнэлт (жил тутамд)

4.4 сая.төгрөг

Шаардагдах хөрөнгө оруулалт

28 сар

Хөрөнгө оруулалтын зардал нөхөх хугацаа

8.24 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

44.28%

Эрчим хүчний хэмнэлт (хэрэглээ)

27.42%

Эрчим хүчний хэмнэлт (зардал)

165.2 сая.төгрөг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

53%

Төслийн дотоод өгөөж

26.7%

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

29

АРГА ХЭМЖЭЭ #1

Мах бэлтгэх цехийн уурын конденсаторыг цэвэрлэн засч ашиглалтыг сайжруулах /нэг компрессорд нэг конденсатор ашиглах/

67,500 кВт.цаг/жил

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

9.6 сая.төгрөг

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

4 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

5 сар

Хоронго оруулалтын зардал нөхөх хугацаа

70.2 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #2

Хиамны үйлдвэрийн хөлдөөгч компрессорыг төвлөрсөн хөргөгч компрессороор солих

438,837 кВт.цаг/жил

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

62.7 сая.төгрөг

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

60 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

12 сар

Хоронго оруулалтын зардал нөхөх хугацаа

460.6 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #3

Эрчим хүчний хэмнэлттэй шинэ шахуурга суулгаж хуучин энгийн ус шахагч шахуургуудыг халах

63,360 кВт.цаг/жил

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

9 сая.төгрөг

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

10 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

13 сар

Хоронго оруулалтын зардал нөхөх хугацаа

60.72 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХЭМНЭЛТИЙН ТӨСӨЛ - МАХ ИМПЕКС ХК



Нийт цахилгааны хэрэглээ
(2016) (кВт.цаг): 3,023,896

•Хөргөх байр

•Бэлтгэх цех

•Хиамны цех

•Хөлдөөх цех



АРГА ХЭМЖЭЭ #4

Хиам хөлдөөх системийн SCADA системийг засч бусад хөлдөөгч компрессор болон хөргөх өрөөнүүдтэй нэгтгэх

87,754 кВт.цаг/жил

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

12.5 сая.төгрөг

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

15.0 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

14 сар

Хоронго оруулалтын зардал нөхөх хугацаа

90.31 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #5

Дулааны халуун усны шахалт болон дулаан ялгаруулах ачааллыг зохицуулах Давтамж хувьсгуур суулгах

21,946 кВт.цаг/жил

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

3.13 сая.төгрөг

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

4.4 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

17 сар

Хоронго оруулалтын зардал нөхөх хугацаа

20.33 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #6

Үйлдвэрийн бүх нэгжийн чийдэнг эрчим хүчний хэмнэлттэй LED чийдэнгээр солих

364,584 кВт.цаг/жил

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

52 сая.төгрөг

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

138.1 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

32 сар

Хоронго оруулалтын зардал нөхөх хугацаа

380.68 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #7

Мах бэлтгэх цехд хөргөгчний системийг хянах болон удирдах SCADA систем суулгах

211,500 кВт.цаг/жил

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

30.2 сая.төгрөг

Эрчим хүчний хэмнэлт /жил тутамд/

90.0 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

36 сар

Хоронго оруулалтын зардал нөхөх хугацаа

220.44 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

41.51%

Эрчим хүчний хэмнэлт (хэрэглээ)

41.46%

Эрчим хүчний хэмнэлт (зардал)

179 сая.төгрөг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

51%

Тослийн дотоод огоож

41.5%

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

30

АРГА ХЭМЖЭЭ #1

UPS болон Стабилизаторын өрөөний тасалгааны хэмийг 24°C тохируулах

2,543 кВт.цаг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

0.46 сая.төгрөг

Эрчим хүч зардлын хэмнэлт (жил тутамд)

0.1 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

2.6 сар

Хоронго оруулалтын зардал нохох хугацаа

2.7 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #2

3 ба 4-р дэд станцын трансформаторуудын ачааллыг 2-р дэд станцын трансформаторуудад шилжүүлж нийт ачааллыг тэнцвэржүүлэх

29,237 кВт.цаг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

5.32 сая.төгрөг

Эрчим хүч зардлын хэмнэлт (жил тутамд)

4 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

9 сар

Хоронго оруулалтын зардал нохох хугацаа

31.02 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #3

Барилгын дулааны сүлжээ болон хэрэгцээний халуун усны сүлжээнд температурын удирдах төхөөрөмж,ялтсан бойлер суулгах

476.2 Гкал

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

13.2 сая.төгрөг

Эрчим хүч зардлын хэмнэлт (жил тутамд)

15 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

13.6 сар

Хоронго оруулалтын зардал нохох хугацаа


138.1 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХЭМНЭЛТИЙН ТӨСӨЛ - МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗ



Нийт цахилгааны хэрэглээ
(2016) (кВт.цаг): 3,204,000



Эйр Кондишн



Мотор



Гэрэлтүүлэг



Усны насос

АРГА ХЭМЖЭЭ #4

Бүх нэгжийн чийдэнг эрчим хүчний хэмнэлттэй LED чийдэнгээр солих

548,935 кВт.цаг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

99.8 сая.төгрөг

Эрчим хүч зардлын хэмнэлт (жил тутамд)

245.3 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

30 сар

Хоронго оруулалтын зардал нохох хугацаа

582.42 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

АРГА ХЭМЖЭЭ #5

Гэрэлтүүлгийн хэрэглээг багасгах зорилгоор студи, бичлэгийн өрөө, оффис болон коридорт хөдөлгөөн мэдрэгч суулгах

86,376 кВт.цаг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

15.7 сая.төгрөг

Эрчим хүч зардлын хэмнэлт (жил тутамд)

47 сая.төгрөг

Шаардагдах хоронго оруулалт

36 сар

Хоронго оруулалтын зардал нохох хугацаа

91.64 тонн

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

20.82%

Цахилгааны хэмнэлт (хэрэглээ)

10.5%

Дулааны хэмнэлт (хэрэглээ)

18.62%

Эрчим хүчний хэмнэлт (зардал)

134 сая.төгрөг

Эрчим хүчний хэмнэлт (жил тутамд)

96%

Тослийн дотоод огоож

18%

Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

Төсөөлж буй үр дүн

Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэглээ 2017 оны гүйцэтгэлээр:

Цахилгаанд: 4239 сая кВт.ц = **56%**

Дулаанд: 280870 Гкал/жил = **4%**

Нийт: 4570 сая кВт.ц



15% хэмнэлт гаргахад

- Эрчим хүчний хэмнэлтийн үр дүнд **685,5 сая кВт.ц** буюу **678,6 мянган тн CO₂** хүлэмжийн хийг агаар мандалд ялгаруулахаас урьдчилан сэргийлнэ;
- 685,5 сая кВт.ц гэдэг **228,0 мянган өрхийн** жилийн эрчим хүчний хэрэглээ;
- Хэрэглэгч талдаа үйл ажиллагааны зардлаасаа **90 орчим тэрбум төгрөг** хэмнэнэ.

Ач холбогдол ХЭРЭГЛЭГЧ танд:

Зардал
буурна.

- Зардлын хэмнэлтээс бий болсон хөрөнгийг өөр зүйлд зарцуулах, хөрөнгө оруулах боломж бүрдэнэ.

Бүтээмж
нэмэгдэнэ.

- Үр ашиг бүхий техник технологийг үйл ажиллагаандаа ашиглах боломж бүрдэнэ.

Өрсөлдөх
чадвар
сайжирна.

- Нэгж бүтээгдэхүүний чанар сайжрах, өртөг буухар боломж бүрдэнэ.

Улс орны эдийн
засаг хурдсах

Барилгын салбарт эрчим хүч хэмнэх боломж:

2000 оноос өмнө баригдсан 3 сая м² талбай бүхий 430 орчим угсармал орон сууц байна.

10 сая м² талбайг халаах дулааны эрчим хүчээр 3 сая м² талбайг халааж, нийт түгээж буй дулааны 20% орчмыг зарцуулдаг.



Барилга	Дулааны нийт хэрэглээ (кВтцаг/жил)	Халаах талбайн хэмжээ (м2)	1м2 талбайд ноогдох хэмжээ (кВтцаг/м2)
Шинэчлэн дулаалсан барилга	221.900	1435	154.63
Харьцуулсан барилга	397.490	1435	277
Хэмнэлт	30%		

Төсвийн байгууллагуудад эрчим хүч хэмнэх боломж:

2017 оны байдлаар:

- Төсвөөс санхүүждэг **2909** байгууллага, эдгээр байгууллагын 80% орчим нь дулааны тоолуургүй байна.
- Улсын хэмжээнд нийт 640 сургуулийн барилга байна. Түүний халаалтад 173 тэрбум төгрөг төсөвлөн зарцуулснаас 480 орчим нь задгай тооцдог буюу тоолуургүй.
- Ижил талбайтай 2 сургуулийн халаалтын зардалд тоолууртай нь 17 сая, тоолуургүй нь 40 сая төсвөөс санхүүжсэн.

Орон нутагт эрчим хүч хэмнэх талаар хэрэгжүүлсэн сайн туршлага:

- ХОВД, ЗАВХАН аймаг;
- 2014-2017 оны хооронд;
- Нийт 16 сургууль, цэцэрлэг, эмнэлэг, г.м.
- Дулаалахаас өмнө 7,75 сая кВт.ц жил
- Дулаалсаны дараа 2,98 сая кВт.ц жил
- Хэмнэлт 61%





МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТУШААЛ

2018 оны 04 дүгээр
сарын 09-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар
хот

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай


Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 274 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр(2018-2022 он)-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

2. “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг салбар хоорондын уялдааг ханган зохион байгуулах, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хороонд даалгасугай.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусган, гадаадын зээл тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, төр-хувийн хэвшлийн түншлэлийг ашиглах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг бүх сайд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

Үйл ажиллагаа – 60, Бүтээгдэхүүн – 83,
Хамтран хэрэгжүүлэгч - 43:





Санхүүжилтын эх үүсвэр

№	Санхүүжилтын эх үүсвэр	хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Төсөв <i>/сая төг/</i>
1	Гадаадын зээл тусламж	27	4250
2	Норм, Нормчлолын сан	11	250
3	Хувийн хэвшил	9	2100
4	Төр, хувийн хэвшлийн түншлэл	7	2000
5	Улс, орон нутгийн төсөв	5	5500
	Нийт	64	13650



САНГИЙН ЯАМТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ

1. Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад **дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох**, хүрсэн үр дүнгээс нь хамааруулан **татварын бодлогоор дэмжих тогтолцоог** бүрдүүлэх;
2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвийн байгууллагад эрчим хүчний хэмнэлтийг дэмжсэн урамшууллын тогтолцоог бий болгох, зардлын хэмнэлт, хүрсэн үр дүн, бодит хэмнэлттэй уялдсан урамшууллын хэмжээ, шалгуур үзүүлэлтийг хамтран тодорхойлох, тоолууржуулах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх;
3. Эрчим хүчний хэмнэлтээс бий болсон жилийн урсгал зардлын хэмнэлтийн тодорхой хувийг эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх дараагийн үйл ажиллагаанд зарцуулах тогтолцоог бүрдүүлж, хэмнэх сэдэл, санаачилгыг дэмжих;
4. Төсвийн алдагдал, үр ашиггүй зардлыг бууруулах зорилгоор **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн** дагуу худалдан авах бүтээгдэхүүн, бараа, ажил, үйлчилгээ, тоног төхөөрөмжид эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын хугацааны зардал бага байх шалгуурыг тогтоох, тооцоо судалгааг хамтарч гүйцэтгэх;



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ

1. Барилгын эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэлийг тогтоох судалгааг хийж гүйцэтгэх, барилга байгууламжийн эрчим хүчний хэрэглээний түвшинг тодорхойлох аргачлал боловсруулах, эрчим хүчний аудитыг барилгын салбарт үе шаттайгаар хийж эрчим хүчний хэрэглээний түвшинг тодорхойлох, ногоон барилгын үнэлгээний системийг хэрэгжүүлэх, эрчим хүчний хэрэглээг үндэслэн шошгожуулах, хяналт тавих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
2. Барилгын дулааны алдагдлыг бууруулах эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг дэмжсэн зээл, санхүүжилтийн механизм бий болгоход холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
3. Барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, хэрэгжилтийг хангуулж, гүйцэтгэлд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, норм, дүрмийг боловсронгуй болгох чиглэлээр хамтран ажиллах;
4. Барилгын эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр ажиллах хүний нөөцийг бэлтгэх, чадавх бэхжүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй барилга, барилгын материалын үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих, олон нийтийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ

1. Ногоон хөгжлийн бодлого, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн уялдааг ханган үр дүнтэй хэрэгжүүлэх, бодлогын баримт бичгүүдэд туссан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд жишиг төсөл, хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх;
2. Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээнээс ялгарч байгаа хүлэмжийн хийг тооцох үндэсний онцлогт тохирсон аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, үндэсний хэмжээний хүлэмжийн хийн тооллогын системийг бэхжүүлж мэдээллийн сан бий болгох;
3. Эрчим хүч хэмнэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зохицуулалтыг бий болгож, уур амьсгалын сан, олон улсын байгууллагаас хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;
4. Эрчим хүч хэмнэх үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж салбар хоорондын уялдааг хангах ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;



УУХҮЯ, ХХААХҮ ЯАМДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ

1. Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, аж үйлдвэрийн салбар дахь нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээнд зарцуулах эрчим хүчний зарцуулалтын нормыг тодорхойлж, эрчим хүчний зарцуулалтыг үе шаттайгаар бууруулах;
2. Уул уурхай, хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд нь бодлогын хувьд дэмжлэг үзүүлж, чиглэл өгч ажиллах, тус салбарын үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, хяналтын тогтолцоонд эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлыг дүгнэх үзүүлэлтийг оруулах;
3. Үйлдвэрлэлийн салбарт шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, эрчим хүчний удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлэхэд хамтран ажиллах;
4. Салбарын инженер, техникийн ажилтныг чадавхжуулах, хэмнэлт, үр ашгийн чиглэлээр мэдлэг олгоход хамтран ажиллах;



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ

1. Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээний хичээлийг ерөнхий боловсролын сургалтын агуулгад тусгах, эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээний хичээлийг улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлж, тогтмолжуулахад бодлогоор дэмжих;
2. Бүх шатны боловсролын байгууллага, олон нийтэд эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай хэрэглээний тогтвортой хөгжлийн боловсрол олгох чиглэлд мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлэх;
3. Яамны харьяа үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд бодлогын хувьд дэмжиж ажиллах, сургууль, цэцэрлэгийн эрчим хүчний алдагдлыг бууруулах чиглэлээр бодлогын хувьд зөвлөмж өгч, хамтран ажиллах;




ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**ЭРЧИМ ХҮЧЭЭ ХЭМНЭЖ
ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАЙРЛААРАЙ**



www.facebook.com/Эрчим-хүчний-үнэ-цэнэ



Та манай Facebook хуудсанд зочлоорой.

Санал болгож буй эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээ:



Төсөвт байгууллага

